



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 291 тоот тогтоол, 2020 оны А-/890 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Оюуны өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон хавсралтад заасан 121 нэр төрлийн 215,504,211,87 /хоёр зуун арван таван сая таван зуун дөрвөн мянга хоёр зуун арван нэгэн төгрөг наян долоон мөнгө/-ийн балансын үнэтэй хөрөнгө, 109 ширхэг 419,650 /дөрвөн зуун арван есөн мянга зургаан зуун тавин төгрөг/-ийн үнэт цаасыг акталж, устгах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч	Ч.Эрдэнэбаяр	- Байцаагч
Нарийн бичгийн дарга:	Э.Оюунцэцэг	- Нягтлан бодогч
Гишүүд:	Б.Шүр-Эрдэнэ	- Сүлжээний инженер
	Б.Цэндээхүү	- Байцаагч
	С.Түвшинбаяр	- Гэрээт ажилтан

2. Хавсралтад заасан хөрөнгийг акталж устгах ажлыг холбогдох хууль, журмын дагуу 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч Ч.Эрдэнэбаярт, ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг “Өмч хамгаалах зөвлөл”-ийн дарга /Д.Бат-эрдэнэ/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

000576